

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/045/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2025
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Нямсүрэн

Утас: 70272248 Цахим хаяг: nyamsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМГИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГА
С.ТАМИР ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Жолоочийн тооцооны хуудас бөглөдөггүй, албан ажлын шаардлагаар бус Улаанбаатар хот руу шатахуун зарцуулсан;
- Дотоод албан томилолтын зардалд анхан шатны баримтын бүрдэлгүй, томилолтын хуудас, удирдамж, төлөвлөгөөгүй;
- Дотоод албан томилолтын зардлаас хоолны хөнгөлөлтийн дүнг суутгаагүй;

зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8, Хувь хүний орлогын татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 22 дугаар зүйлийн 22.1.1-д заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

411000101

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх АЗ сертификатын сургалтыг 27 сумд, аймгийн төвийн төсөвт байгууллагуудыг хамруулан зохион байгуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, сургалтын багшийн зардал болох 13,019.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлэн зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх 126 төслийн 29.5 тэрбум төгрөгийн тендер зарлахаас 33 төслийн 2.7 тэрбум төгрөгийн тендер нь өмнөх оны шилжих үлдэгдэл, энэ оны 93 төслийн 26.5 тэрбум төгрөгийн тендерээс 82 төслийн 23.7 тэрбум төгрөгийн тендерийг зарлаж цахим системд бүртгэсэн байна. 11 төслийн 2.7 тэрбум төгрөгийн тендер дараа онд зарлахаар шилжих үлдэгдэл болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт, 59 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 88,9 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	13,606,200.00	18,128,100.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,606,200.00	18,128,100.00
354	Хангамжийн материал	13,606,200.00	18,128,100.00
35410	Бичиг хэргийн материал	2,296,500.00	2,834,400.00
35420	Аж ахуйн материал	6,237,700.00	7,233,700.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,516,000.00	8,060,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,556,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	101,294,517.84	90,176,946.42
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	101,294,517.84	90,176,946.42
392	Биет хөрөнгө	99,693,684.53	83,806,113.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,000,000.00	88,636,067.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,166,666.64)	(46,846,066.92)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,522,940.00	48,522,940.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,330,337.04)	(21,091,544.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,620,120.00	21,090,120.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,952,371.79)	(6,505,402.00)
393	Биет бус хөрөнгө	1,600,833.31	6,370,833.26
39301	Програм хангамж	1,700,000.00	6,900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(99,166.69)	(529,166.74)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	114,900,717.84	108,305,046.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,374,534.19	3,139,019.54
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,374,534.19	3,139,019.54
413	Өглөг	1,374,534.19	3,139,019.54
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,374,534.19	377,239.54
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	16,830.00
4136	Бусад өглөг	-	2,744,950.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,744,950.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	113,526,183.65	105,166,026.88
51	Засгийн газрын хувь оролцоо	113,526,183.65	105,166,026.88
512	Хуримтлагдсан үр дүн	113,526,183.65	105,166,026.88
51210	Өмнөх үеийн үр дүн	-	113,526,183.65
51220	Тайлант үеийн үр дүн	113,526,183.65	(8,360,156.77)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	114,900,717.84	108,305,046.42

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,992,197.50	426,509,574.33
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,526,997.50	92,952,774.33
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	57,051,774.33
131104	Дээд шатны төсвийн захирагчид тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,526,997.50	35,901,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	314,465,200.00	333,556,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	314,465,200.00	333,556,800.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	63,730,117.62	-
120	Нийтлэг татварын бус орлого	63,730,117.62	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	63,730,117.62	-
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	449,722,315.12	426,509,574.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	336,196,131.47	434,869,731.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	307,258,709.77	422,417,774.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,759,035.79	321,863,793.40
210101	Үндсэн цалин	123,449,547.16	172,348,805.84
210102	Нэмэгдэл	97,941,698.34	125,300,248.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,788,000.00	9,810,745.29
210104	Урамшуулал	14,579,790.29	14,403,994.25
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,094,209.20	40,053,080.07
210201	Тэтгэврийн даатгал	20,209,378.97	27,236,094.32
210202	Тэтгэмжийн даатгал	3,752,108.17	3,204,246.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,188,787.01	1,602,123.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,188,787.01	1,602,123.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4,755,148.04	6,408,492.87
2104	Хангамж, бараа материалын зардал	12,194,795.00	14,337,950.00
210401	Бичиг хэрэг	2,100,520.00	2,361,150.00
210402	Тээвэр, шатахуун	6,178,400.00	8,797,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,167,665.00	1,678,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,717,210.00	1,481,300.00
210408	Бараа материал акталсны зардал	31,000.00	19,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,037,600.00	710,000.00
210604	Урсгал засвар	1,037,600.00	710,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,182,000.00	2,520,000.00
210702	Дотоод албан томилолт	3,182,000.00	2,520,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,634,750.00	16,230,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,026,750.00	13,019,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	1,680,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	61,380.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	440,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,356,319.78	26,702,271.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,264,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.00	1,360,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,606,319.78	21,077,571.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,937,421.70	12,451,956.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,817,693.88	400,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,405,593.88	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	412,100.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,119,727.82	12,051,956.21
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,960,614.92	3,924,950.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	159,112.90	8,127,006.21
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	336,196,131.47	434,869,731.10
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	113,526,183.65	(8,360,156.77)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,992,197.50	426,509,574.33
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	71,526,997.50	92,952,774.33
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	57,051,774.33
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	64,526,997.50	35,901,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,000,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	314,465,200.00	333,556,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	314,465,200.00	333,556,800.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	385,992,197.50	426,509,574.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,054,775.80	414,057,618.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	242,759,035.79	322,861,088.05
210101	Үндсэн цалин	123,449,547.16	173,723,340.03
210102	Нэмэгдэл	97,941,698.34	125,300,248.02
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,788,000.00	9,433,505.75
210104	Урамшуулал	14,579,790.29	14,403,994.25
210105	Гэрээт ажлын хөлс		
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/		
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,719,675.01	40,053,080.07
210201	Тэтгэврийн даатгал	20,209,378.97	27,236,094.32
210202	Тэтгэмжийн даатгал	2,377,573.98	3,204,246.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,188,787.01	1,602,123.24
210204	Ажилгүйдлийн даатгал	1,188,787.01	1,602,123.24
210205	Эрүүл мэндийн даатгал	4,755,148.04	6,408,492.87
2104	Хангамж, бараа материалын зардал	12,769,755.00	11,944,020.00
210401	Бичиг хэрэг	2,612,400.00	2,843,050.00
210402	Тээвэр, шатахуун	7,734,400.00	7,241,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,354,185.00	651,970.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,068,770.00	1,207,300.00
2106	Эд хопшил, урсгал засварын зардал	62,809,560.00	14,896,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	35,417,400.00	-
210602	Тавилга	16,753,320.00	470,000.00
210604	Урсгал засвар	10,638,840.00	14,426,750.00
2107	Томилолт, зочны зардал	3,182,000.00	2,520,000.00
210702	Дотоод албан томилолт	3,182,000.00	2,520,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,064,750.00	20,422,680.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,756,750.00	13,019,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	1,680,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	61,380.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,700,000.00	5,640,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	750,000.00	1,360,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.00	1,360,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,937,421.70	12,451,956.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,817,693.88	400,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	22,405,593.88	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	412,100.00	400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,119,727.82	12,051,956.21
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,960,614.92	3,924,950.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	159,112.90	8,127,006.21
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C07	Тайлант үеийн үр дүн	113,526,183.65	113,526,183.65
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	113,526,183.65	113,526,183.65
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	113,526,183.65	113,526,183.65
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	113,526,183.65	113,526,183.65
D08	Тайлант үеийн үр дүн	(8,360,156.77)	(8,360,156.77)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	105,166,026.88	105,166,026.88

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	326,510,000.00	333,556,800.00	(7,046,800.00)	102.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,510,000.00	333,556,800.00	(7,046,800.00)	102.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	326,109,900.00	325,029,793.79	1,080,106.21	99.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	272,834,500.00	272,044,805.59	789,694.41	99.71
210101	Үндсэн цалин	175,008,800.00	173,723,340.03	1,285,459.97	99.27
210102	Нэмэгдэл	76,600,600.00	74,483,965.56	2,116,634.44	97.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,560,000.00	9,433,505.75	1,126,494.25	89.33
210104	Урамшуулал	10,665,100.00	14,403,994.25	(3,738,894.25)	135.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,104,300.00	33,817,588.20	286,711.80	99.16
210201	Тэтгэврийн даатгал	23,310,400.00	22,995,959.96	314,440.04	98.65
210202	Тэтгэмжийн даатгал	2,698,500.00	2,705,407.03	(6,907.03)	100.26
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,349,200.00	1,352,703.55	(3,503.55)	100.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,349,200.00	1,352,703.55	(3,503.55)	100.26
210205	Эрүүл мэндийн даатгал	5,397,000.00	5,410,814.11	(13,814.11)	100.26
2104	Хангамж, бараа материалын зардал	7,878,400.00	7,875,420.00	2,980.00	99.96
210401	Бичиг хэрэг	1,799,700.00	2,079,950.00	(280,250.00)	115.57
210402	Тээвэр, шатахуун	4,941,800.00	4,941,700.00	100.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	935,000.00	651,970.00	283,030.00	69.73
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	201,900.00	201,800.00	100.00	99.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,648,700.00	2,648,600.00	100.00	100.00
210604	Урсгал засвар	2,648,700.00	2,648,600.00	100.00	100.00
2107	Томиллолт, зочны зардал	2,520,100.00	2,520,000.00	100.00	100.00
210702	Дотоод албан томиллолт	2,520,100.00	2,520,000.00	100.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,763,800.00	4,763,380.00	420.00	99.99
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100.00	-	100.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,680,100.00	1,680,000.00	100.00	99.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,500.00	61,380.00	120.00	99.80
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,100.00	22,000.00	100.00	99.55
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	3,000,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,360,100.00	1,360,000.00	100.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,360,100.00	1,360,000.00	100.00	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,100.00	8,527,006.21	(8,126,906.21)	2,131.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,100.00	400,000.00	100.00	99.98
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,100.00	400,000.00	100.00	99.98
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,127,006.21	(8,127,006.21)	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	8,127,006.21	(8,127,006.21)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Аудитаар нийт 13,652.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд болон мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн орлогыг 436.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Санхүүгийн үр дүнгийн тайлан болон Мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн 12,488.7 мянган төгрөгийг улсын төсөв, нэмэлт санхүүжилтээр салгаж тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3. Санхүүгийн байдлын тайланд байгууллагад төлөх өглөг 727.0 мянган төгрөгийг тооцоо нийлээгүй бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 20,286.0 мянган төгрөгийн зөрчлөөс 10,057.0 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6,526.9 мянган төгрөгөөр давсан тул **“Хязгаарлалттай”** дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 20,286.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 272.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 16,385.0 мянган төгрөгийн 4 албан шаардлага өгч, 3,629.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд 2,520.0 мянган төгрөгийн дотоод томилолтын зардал гарснаас 5 албан хаагчтай холбоотой 23 өдрийн 92.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийн дүнг суутгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.” гэж заасныг мөрдөөгүй, санхүүгийн тайлагналын бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2. 2025 оны 4 дүгээр сард гарсан 180.0 мянган төгрөгийн дотоод томилолтын зардал нь анхан шатны баримтын бүрдэлгүй, томилолтын хуудас, удирдамж, төлөвлөгөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Тайлант оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 183 мэдээллийг мэдээлэхээс 23 мэдээлэл хугацаа хоцроосон ба өмч хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг мэдээлээгүй байна. Мөн өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 5 дугаар зүйлийн 5.1, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, Төрийн хэмнэлтийн тухайн хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг тус тус үндэслэн албан шаардлага өгөв.

2. Тайлант онд тушаал шийдвэргүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байгууллагын танилцуулах веб сайтыг Метадата ХХК-тай хамтран 5,200.0 мянган төгрөгөөр гэрээ хийж шууд худалдан авалт хийсэн байна. Сайтын хөгжүүлэлт хангалтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн

18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

3.Тайлант онд 5115ТӨН улсын дугаартай Hyundai sonata суудлын автомашиныг аймгийн ЗДТГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан ба 6,600.0 мянган төгрөгийн мотор эд ангийг засварласан боловч хэвийн ажиллахгүй байгаа зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан,зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

4. Тайлант онд нийт 8,797.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь өмнөх оноос 29,7 хувиар илүү зарцуулсан ба жолоочийн тооцооны хуудас бөглөдөггүй, албан ажлын шаардлагаар бус 58 удаа Улаанбаатар хот руу 4,585.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “сахилга баттай байх”, 4.2.1-д “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах”, 6 дугаар зүйлийн 6.2-т “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.4-д “Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан,зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн” гэж заасныг үндэслэн албан шаардлага өгөв.

5.3 Зөвлөмж

1. Татвар, торгуультай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын дансанд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгсэл нийт 112.5 мянган төгрөгийн татвар төлөөгүй, 377.5 мянган төгрөгийн торгуультай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, Монгол Улсын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2-т “Аж ахуйн нэгж, байгууллага авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор багтаан төсөвт төлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх

удирдлага хүлээнэ” гэсэн заалтыг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид татварыг цаг хугацаанд нь төлж, торгуулийг зөрчил гаргасан этгээдийг тогтоож төлүүлэх.

2. Өр төлбөр данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллага нь тайлант онд НДШ-ийн өглөг 377.2 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 2,761.8 мянган төгрөг нийт 3,139.0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны дотор, биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган
төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын дансанд бүртгэлтэй 2 тээврийн хэрэгсэл нийт 112.5 мянган төгрөгийн татвар төлөөгүй, 377.5 мянган төгрөгийн торгуультай байна. Мөн хадгалалт хамгаалалт хангалтгүй байна.	1	490.0					1	490.0
Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 183 мэдээллийг мэдээлэхээс 23 мэдээлэл хугацаа хоцроосон ба өмч хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг мэдээлээгүй байна. Мөн өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-			1	-		
Тайлант онд тушаал шийдвэргүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй байгууллагын танилцуулах веб сайтыг Метадата ХХК-тай хамтран 5,200.0 мянган төгрөгөөр гэрээ хийж шууд худалдан авалт хийсэн байна. Сайтын хөгжүүлэлт хангалтгүй байна.	1	5,200.0			1	5,200.0		
Тайлант онд 5115ТӨН улсын дугаартай Hyundai sonata суудлын автомашиныг аймгийн ЗДТГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан ба 6,600.0 мянган төгрөгийн мотор эд ангийг засварласан боловч хэвийн ажиллахгүй байгаа зөрчил илэрлээ.	1	6,600.0			1	6,600.0		
Тайлант онд нийт 8,797.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь өмнөх оноос 29,7 хувиар илүү зарцуулсан ба жолоочийн тооцооны хуудас бөглөдөггүй, албан ажлын шаардлагаар бус 58 удаа Улаабаатар хотруу 4,585.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулж явсан байна.	1	4,585.0			1	4,585.0		
Тайлант онд 2,520.0 мянган төгрөгийн дотоод томилолтын зардал гарснаас 5 албан хаагчтай холбогдсон 23 өдрийн 92.0 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийн дүнг суутгаагүй байна.	1	92.0	1	92.0				
2025 оны 4 дүгээр сард гарсан 180.0 мянган төгрөгийн дотоод томилолтын зардал нь анхан шатны баримтын бүрдэлгүй, томилолтын хуудас, удирдамж, төлөвлөгөөгүй байна.	1	180.0	1	180.0				
Тус байгууллага нь тайлант онд НДШ-ийн өглөг 377.2 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 2,761.8	1	3,139.0					1	3,139.0

мянган төгрөг нийт 3,139.0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.								
Дүн	8	20,286.0	2	272.0	4	16,385.0	2	3,629.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn